



ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 01 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Г Байгууллагын удирдлагын баг
байгуулах тухай Г

Газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 2.2, 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын удирдлагын багийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга

Байгууллагын дарга

Гишүүд

Үйл ажиллагааны албаны дарга

Хүний нөөцийн менежер

Нягтлан бодогч

Инженер

2. Байгууллагын удирдлагын багийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хуулийн зөвлөх-д үүрэг болгосугай.

ДАРГА М.ГОНЧИГЖАВ



Газрын даргын 2014-оны 10 дугаар сарын
01-ны өдрийн 10 тоот тушаалын хавсралт
ондлалт

**Эмээлтийн хөнгөн үйлдвэрлэл, үйлдвэрийн технологийн парк
ОНӨТҮГ-ЫН Удирдлагын багийн ажиллах журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1."Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн, үйлдвэрлэл технологийн парк" ОНӨТҮГ-ЫН даргын дэргэд зөвлөх эрх бүхий удирдагын баг ажиллана. Удирдлагын багийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах, хурлаас гарах шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Удирдлагын багийн гишүүдийн эрх үүргийг тодорхойлох, үйл явцыг шуурхай удирдлагаар хангахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Удирдлагын багийн хурлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлыг авч хэлэлцэн шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Удирдлагын багийн Зөвлөлийн бүтэц зохион байгуулалт

- 2.1.Удирдлагын багийг Байгууллагын дарга удирдана.
- 2.2.Удирдлагын багийн бүрэлдэхүүнийг даргын тушаалаар томилно.
- 2.3.Удирдлагын багийн хурлыг сард 1-ээс доошгүй удаа заавал хуралдуулна.
- 2.4.Шаардлагатай үед даргын санаачлагаар хуралдуулж болно.
- 2.5.Удирдлагын багийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэнд байгууллагын Хуулийн зөвлөх хяналт тавьж ажиллана.

Гурав. Удирдлагын багийн хурлын хэлэлцэх асуудал

- 3.1.Байгууллагын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх заавар журам, тушаал шийдвэрийн төслийг хэлэлцэн батлах.
- 3.2.Ажилтан шинээр ажилд авах, дотроо шилжүүлэн ажиллуулах, ажлаас халах, сахилгын шийтгэл ногдуулах, шагнал урамшилд тодорхойлох, тэтгэвэр тэтгэмж олгохтой холбоотой асуудлыг хэлэлцэх.
- 3.3.Тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн ажлын явцтай танилцах, дүгнэлт өгөх, шийдвэр гаргах
- 3.4.Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг хэлэлцэх.
- 3.5.Сар бүр ажилтан, албан хаагчдын ажлын дүнг хэлэлцэх.
- 3.6.Хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хэлэлцэх.
- 3.7.Сар бүрийн санхүүжилтийн хэрэгжилт, дараа сарын санхүүгийн төлөвлөлт, санхүүгийн улирлын болон жилийн эцсийн тайланг танилцуулах
- 3.8.Ирсэн албан бичгийн шийдвэрлэлт

- 3.9. Байгууллагын даргын тушаалын хэрэгжилт
- 3.10. Удирдлагын багийн гишүүдийн саналын хуудсанд олонх гишүүдийн санал авсан асуудлыг хурлаар авч хэлэлцүүлнэ. Заавал удирдлагын багийн хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан хэвлэж тараах, цахим хэлбэрт бэлтгэж танилцуулна.

4 Дөрөв. Удирдлагын багийн хурлын үйл ажиллагаа, дэг

- 4.1 Удирдлагын багийн хурлыг сар бүрийн сүүлийн 7 хоногийн даваа гаригийн 15 цагт байгууллагын дарга, түүний түр эзгүйд албаны дарга удирдан хуралдуулж болно.
- 4.2 Удирдлагын багийн хурлыг гишүүдийн 60 хувь буюу түүнээс дээш ирцтэй хурлыг хүчинтэйд тооцно. Удирдлагын багийн хурлын шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 4.3 Удирдлагын багийн хурлаар хэлэлцэх асуудлыг зөвхөн тухайн асуудлыг хариуцсан удирдлагын багийн гишүүн оруулна.
- 4.4 Шаардлагатай үед Удирдлагын багийн хуралд хэлэлцэх асуудалтай холбоо бүхий ажилтан, албан хаагчдыг татан оролцуулж болно.
- 4.5 Удирдлагын багийн хурлын тэмдэглэлийг хуулийн зөвлөх хөтөлж, хурлаас гаргасан шийдвэрийг ажилтан, албан хаагчдад танилцуулах үүрэг хүлээнэ.

Тав. Удирдлагын багийн гишүүдийг шагнаж урамшуулах, хариуцлага тооцох

- 5.1. Гишүүд нь сар бүр нэгээс доошгүй хэлэлцэх асуудлыг удирдлагын багийн хуралд оруулах үүрэгтэй.
- 5.2. Санал оруулсан гишүүн бүрт 50.000 төгрөгийн урамшуулал олгоно.
- 5.3. Удирдлагын багийн хуралд улиралд 3-аас доошгүй асуудал хэлэлцүүлээгүй, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулсан, шийдвэр гарахаас өмнөх үеийн мэдээллийг гадагш гаргах тохиолдолд гишүүнийг удирдлагын багийн бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлнө.